

МОНГОЛЫН АХМАДУУД

Ахмад настан бусадтай
адил эрхтэй.
Нас ахих тусам эрх нь
бүдгэрэх ёсгүй...



Монгол улсын нийт хүн амын
10 хүн тутмын нэг нь **ахмад** настан



“Ахмад настны тухай” хууль зэрэг
ахмад настантай холбоотой үйл
ажиллагааг зохицуулсан хууль
ТОГТООМЖИЙН ТОО:




32 хууль



23 тогтоол,
тушаал

Монгол хүний дундаж
наслалт: 71.012 жил





АХМАД НАСТНЫ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЭРХ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 5 дахь хэсэгт “...өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй” гэж заасан.

Өндөр насны тэтгэвэр



Нийгмийн даатгалын сангаас **488,000** иргэн тэтгэвэр авч байгаа бөгөөд **10** хүн тутмын **7** нь тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авч байна.

Тэтгэврийн хэмжээ:
Бүрэн тэтгэврийн доод хэмжээ **650,000** төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ **540.000** төгрөг

? Тулгамдаж буй асуудал:

1. Өндөр насны тэтгэвэр нь амьжиргааны наад захын хэрэгцээг хангаж чадахгүйгээс ахмадууд тэтгэврийн хэмжээндээ сэтгэл хангалуун бус байна.
2. Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлсэн ч итгэлцүүрийг ашигладаггүйгээс тэтгэврийн зөрүүг улам ихэсгэж байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Ахмад настанд үзүүлж буй нийгмийн халамжийн үйлчилгээний төрөл



ТЭТГЭВЭР:
4607 ахмад
настанд
12,892,891.1
сая төгрөг



ТЭТГЭМЖ:
Байнгын
асаргаанд
2,9 мянган
ахмад настан



ҮЙЛЧИЛГЭЭ:
2200 ахмад
настанд
170,621,080
сая төгрөг

Нийгмийн хөгжлийн үйлчилгээ:

Ахмад настанд чиглэсэн боловсролыг дэмжих үйлчилгээ, эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ, хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэнд хүнсний бүтээгдэхүүн худалдан авах хүнс тэжээлийн дэмжлэг гэсэн 3 төрлийн үйлчилгээ

**Алдар цолтой
ахмад настанд
үзүүлэх тусламж
хөнгөлөлт**

3245 алдар цолтон
686,4 сая төгрөг



**Ахмад настанд
олгох насны
хишиг**

168201
ахмад настан



**Эхийн алдар
одонгийн
мөнгөн
урамшуулал:**

39,303 хүн
30465.7 төгрөг



Ахмад настанд:

Протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлт, орон сууцны үнийн хөнгөлөлт, амралт сувиллын үнийн хөнгөлөлт тээврийн хэрэгслийн үнийн хөнгөлөлт зэрэг үйлчилгээ үзүүлж байна.



Тулгамдаж буй асуудал:

1. Ганц бие болон хэвтрийн, хөгжлийн бэрхшээлтэй, гэр оронгүй ахмад настны нийгмийн халамжийн үйлчилгээ сул, хүртээмжгүй байна.

2. Нийгмийн халамжийн үйлчилгээний төрөл, хүртээмжийн талаарх мэдээлэл хомс байна. Тухайлбал ахмад настанд насжилтаас үүдэлтэй өвчлөл, гэмтэлд өртөх эрсдэл их тохиолддог ч мэдээлэл дутмагаас протез, ортопед болон тусгай хэрэгслийн хөнгөлөлт, тусламж үйлчилгээнд бүрэн хамрагдаж чаддаггүй байна.

3. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах нийгмийн хэрэгцээ, ахмад настны тоо өндөр байгаа ч хүртээмж бага байна. Тухайлбал ахмад настануудад зориулсан төрөлжсөн асрамжийн газрууд цөөн, санжүүжилт бага байна.

АХМАД НАСТНЫ ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛУУЛАХ ЭРХ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 6 дахь хэсэгт эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхийг баталгаажуулж, эрүүл мэндийн эрхийн харилцааг Эрүүл мэндийн тухай, Нийгмийн халамжийн тухай, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиудаар зохицуулжээ.

Эрүүл мэндийн байгууллагуудын ахмад настны кабинет:
Улсын хэмжээнд 10 эмч, 4 сувилагч, ахмадын 19 кабинет байна.



10 эмч



4 сувилагч



19 кабинет



Эх сурвалж: ХЭҮК, 22 дахь илтгэл 394 дахь тал



Тулгамдаж буй асуудал:

1. Нийслэл болон орон нутагт ахмад настнуудын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй авч чадахгүй
2. Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй байна. Урт хугацааны тусламж үйлчилгээ үгүйлэгдэж байна.
3. Насан өндөр болсноор эмзэг байдал, танин мэдэхүйн чадвар буурах нь насжилтын хэвийн үзэгдэл гэх хандлагаас улбаатайгаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ялгаварлан гадуурхалтад өртөж байна.
4. Улсын хэмжээнд гериатр эмч, ахмадын кабинетын хүрэлцээ муу, эрүүл мэндийн үйлчилгээ авахад дугаарлах, чирэгдэл ихтэй, эмийн үнэ өндөр, эмч эмнэлгийн ажилчдын зан харилцааны асуудал, геронтологийн үндэсний төвийн барилга байгууламж, материаллаг бааз, хүний нөөц, санхүүжилтийн хүрэлцээгүй байдал зэрэг нь тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлж байна.

АХМАД НАСТНЫ ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХ

Монгол Улсын хувьд Ахмадын тухай хуулиар ахмадын хөдөлмөрлөх эрхийг баталгаажуулахын зэрэгцээ шинэчлэн батлагдсан Хөдөлмөрийн тухай хуульд ахмад насны хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн тусгайлсан зохицуулалтыг тусгасан.

АЖИЛ ЭРХЛЭЛТ:

180000 | Ажил, хөдөлмөр эрхлэх хүсэлтэй

38500 | Ажилтай

9000 | Байнгын ажлын байртай

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ТОО, ХҮЙСЭЭР:

2022 оны 04-р сарын байдлаар
ХЭҮК /55-аас 70 нас/

64737

54931

АХМАД НАСТНЫ ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ:

28% | Хувиараа бие даасан ажиллагч

7.3% | Байнгын цалин хөлстэй

27.8% | Өрхийн аж ахуй эрхлэгч

11.9% | Түр болон тохиолдлын шинжтэй ажилтай

19.2% | Цалин хөлстэй

ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БҮЙ САЛБАР:



Үйлчилгээний ажилд **3.7** мянга



Газар тариаланд **4.9** мянга



Барилга, тээвэр, үйлдвэрлэлд **1.2** мянга



Мал аж ахуйд **20.7** мянга

АЖИЛ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ ЧАДАХГҮЙ БАЙГАА ШАЛТГААН:

29%
НАС ӨНДӨР

23%
ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХУВЬД ТЭНЦЭХГҮЙ

19%
НАС ЗААГААД
АЖИЛД АВДАГГҮЙ

7%
БИЕД ТОХИРСОН
АЖИЛ БАЙДАГГҮЙ

Тулгамдаж буй асуудал:



1. Ахмад настны тухай хуулийг бүтээлчээр хэрэгжүүлж, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний сүлжээ, бүртгэлийг улсын хэмжээнд дэмжих нэгдсэн дэмжлэг байхгүй.
2. Ахмад настанд тохирсон ажлын байр байдаггүй, цөөн тоогоор олдож буй ажлын байрны талаарх мэдээлэл хангалтгүй, ахмадуудыг ажилд авч буй аж ахуйн нэгжийг татварын урамшууллаар дэмжих бодлого байхгүй байна.

АХМАД НАСТНЫ ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ, ХҮЧИРХИЙЛЛЭЭС АНГИД БАЙХ ЭРХ

Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор ахмад настныг ялгаварлан гадуурхах, дарамт хүчирхийллээс хамгаалахад чиглэсэн чухал зохицуулалтыг тусгасан байна.

Ахмад настны эсрэг хүчирхийлэл: /2022 он/
Гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн улмаас хохирсон ахмад настны тоо **968** байна.

Эх сурвалж: equur.mn

Гадуурхалт:

ХЭҮК-ын судалгаанаас үзэхэд судалгаанд оролцогч **5 ахмад тутмын нэг** нь ялгаварлан гадуурхалтад өртсөн, энэ төрлийн хүчирхийлэл хаана илүү үйлдэгдэж байгааг судалж үзэхэд олон нийт, үйлчилгээний газар ялангуяа дэлгүүр, банк, автобус, эмнэлгийн байгууллагад ялгаварлан гадуурхалтад өртдөг гэж үзжээ.

Насаар ялгаварлан гадуурхах:

Насаар ялгаварлан гадуурхахыг болон хөдөлмөрийн зах зээл дэх ялгаварлан гадуурхалтыг авч үзвэл хамгийн их өртсөн бүлэг нь **55-59** насныхан **40.1 хувь** байна. Үүний дараа **60-64** насны бүлэг **29.5 хувь**, **65-69** насны бүлэг **20.3 хувь**, **70** ба түүнээс дээш насны бүлэг **10.1 хувь** байна.



Хүчирхийллийн төрөл:

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвд хандсан ахмад настны эсрэг үйлдэгдэж буй хүчирхийллийг хэлбэрээр нь авч үзвэл хавсарсан байдлаар

Сэтгэл санааны хүчирхийлэл **64 хувь**,

Бие махбодын хүчирхийлэл **47 хувь**,

Эдийн засгийн хүчирхийлэл **36 хувь**,

Үл хайхрагдах байдал **21 хувь**,

Бэлгийн хүчирхийлэл **0,1 хувийг** эзэлж байна.



Тулгамдаж буй асуудал:

1. Бүхий л салбарт ахмад гэж тоохгүй, хүндэтгэлгүй хандах, ялгаварлан гадуурхах тохиолдол гардаг болох нь судалгаануудын үр дүнгээс харагдаж байна.
2. Ахмад настнууд зөвхөн насаар гэлтгүй гадаад үзэмж, амьжиргааны түвшин, хөгжлийн бэрхшээл, эмэгтэй гэдгээр давхар ялгаварлан гадуурхалтад өртдөг.
3. Ахмад настан нь олон нийтийн газар болон хөдөлмөрийн харилцаанд насаар ялгаварлагдах, гэр бүлийн хүрээнд үл хайхрагдах, хүчирхийлэл дарамтад өртөх явдал цөөнгүй байна.

АХМАД НАСТНЫ ХӨГЖИХ ЭРХ

Ахмад настны тухай хуульд төрөөс ахмад настны эрхийг хангахад тэднийг “нийгмийн амьдралд эрх тэгш оролцуулах, хөгжих, нийгмийн дунд эрүүл, идэвхтэй амьдрах, мэдлэг, туршлагаа хойч үедээ өвлүүлэх боломжтой байх, үл ялгагарлах” зарчмыг хуульчилсан.



Улсын хэмжээнд **441** ахмадын өргөө, танхим үйл ажиллагаа явуулж байна.

Эх сурвалж: ХЭҮК, 22 дахь илтгэл 422 дахь тал

УБ хотод амьдарч буй ахмад настнуудын зөвхөн зөвхөн **64 хувь** нь олон нийтийн үйл ажиллагаанд оролцдог



Тулгамдаж буй асуудал:

1. Ахмад настнууд хувь хүний, нийгмийн, орчны хүчин зүйлээс шалтгаалж нийгмээс өөрийгөө тусгаарлах хандлага байна.
2. Зарим аймаг, сумын ахмадын төвийн байр чанар, стандартын шаардлагад нийцээгүй, байршлын хувьд хүртээмжгүй, тохижилт муу, тав тухгүй, чанарын шаардлага хангахгүй байна.
3. Сумын төв, аймгийн төв, нийслэл хотод ахмад настны чийрэгжүүлэлтийн төв гэрээс нь хол, нийтийн тээврийн хүртээмжгүй байдлаас хамааран нийгмийн үйлчилгээ авах, нийгмийн харилцаанд оролцоход бэрхшээлтэй болгож байна.
4. Ахмад настны оролцоог дэмжих, бие даан амьдрах, нийгмийн амьдралд оролцох, үр шимээс хүртэх эрхэд саад учруулж буй дээрх хүчин зүйлүүдийг арилгах, ялангуяа тэднийг нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах, мэдлэг туршлагаа хойч үедээ өвлүүлэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Хавсралт

Ахмад настантай холбоотой зүйл, заалт бүхий Монгол улсын хуулийн жагсаалт:

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай
3. Монгол улсын засгийн газрын тухай
4. Ахмад настны тухай
5. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай
6. Нийгмийн даатгалын тухай
7. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай
8. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай
9. Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай
10. Хөдөлмөрийн тухай
11. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай
12. Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай
13. Нийгмийн халамжийн тухай
14. Төсвийн тухай
15. Ажилласан жил, тэтгэвийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай
16. Эрүүгийн хууль
17. Ирээдүйн тэтгэврийн нөөц, сангийн тухай
18. Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай
19. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай
20. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
21. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай
22. Эрүүл мэндийн даатгалын тухай
23. Эрүүл мэндийн тухай
24. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
25. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай
26. Тагнуулын байгууллагын тухай
27. Төрийн албаны тухай
28. Байгаль орчныг хамгаалах тухай
29. Соёлын тухай
30. Төр, сүм хийдийн харилцааны тухай
31. Төмөр замын тээврийн тухай
32. Монгол Улсын хилийн тухай



Ахмад настан бусадтай адил эрхтэй. Нас ахих тусам эрх нь бүдгэрэх ёсгүй...



“Өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь заалт)

“Хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмийн хангамж эдлэх, түүнчлэн нэр төрөө хадгалах, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ улс бүрийн бүтэц, нөөц бололцоотой уялдуулан үндэсний хүч чармайлт хийгээд олон улсын хамтын ажиллагааны замаар хэрэгжүүлэх эрхтэй”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 22 дугаар зүйл)

“Ажилгүйдэх, өвчлөх, тахир дутуу болох, бэлэвсрэх, өтлөх, эсхүл өөрөөс үл хамаарах бусад шалтгаанаар амь зуулгагүй болох нөхцөлд тэтгэмж авах эрхтэй”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 25 дугаар зүйл)

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан үндэсний байгууллага юм.

Монгол Улсын иргэн та:


Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө зөрчсөн талаар Монгол Улсын иргэн дангаар, эсхүл хамтарч энэ хуульд заасны дагуу гомдол, мэдээлэл гаргах эрхтэй. / "Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай" хууль, 20 дугаар зүйл.Комисст гомдол, мэдээлэл гаргах эрх/

Холбоо барих

📍 Засгийн газрын 12 дугаар байр,
Барилгачдын талбай-2, Чингэлтэй
дүүрэг, Улаанбаатар хот, 15170

✉ info@nhrcm.gov.mn

☎ 7000-0222



МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

Нобелийн шагналт Олон Улсын Хүний Эрхийн Эмнести Интернэшнл байгууллага нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад баримт бичгүүдэд заасан хүний эрх, эрх чөлөөг хүн бүрд адил тэгш эдлүүлэхийн төлөө үйл ажиллагаа өрнүүлдэг дэлхий нийтийн томоохон хөдөлгөөн бөгөөд Монгол улсад 1994 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Эмнести Интернэшнл нь хүн бүрт эрхийг нь эдлүүлэхийн төлөө хүмүүсийн хүнлэг сэтгэлд тулгуурлан кампанит ажил өрнүүлдэг 10 сая гаурй хүнийг өгнээндээ нэгтгэсэн хүний эрхийн төлөөх дэлхий дахины хөдөлгөөн юм.

Холбоо барих

📍 Улаанбаатар хот, Сүхбаатар
дүүрэг, 6-р хороо, AB Center, 7 давхар

✉ members@amnesty.mn

☎ 7000-4705, 7000-4708

